Чихрийн манжин, хүрэн манжин, тэжээлийн манжингийн талбайн нэг наст хос үрийн талт, зарим үет хог ургамлын эсрэг таримлын соёололтын дараа хэрэглэдэг сонгомол үйлчилгээтэй гербицид.

3 төрлийн үйлчлэх бодисын агууламжтай тул өргөн хүрээний (40 гаруй зүйл) хог ургамалд нөлөөлдөг. 2-7 хоногийн дараа үйлчилгээ мэдэгдэж эхлээд, 2-3 долоо хоногт хог ургамал бүрэн үхдэг. Хог ургамлын үе шатуудад тунг давтамжтай хийвэл илүү үр дүн үзүүлдэг.



Хэрэглэх заавар:

Агаарын хэм: (+5ºC) - (+25ºC)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 6 цагийн зайтай байх
Өвчин хортонд нэрвэгдсэн, гундсан таримал ургамал дээр хэрэглэхийг зөвлөдөггүй.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Чихрийн манжин	Гагдайн төрлүүд царвант шарилж, хээрийн цагаан гич, цагаан лууль, эгэл гаймуу, эгэл халгай, хээрийн бирааги гичгэнэ, зэрлэг цагаан лууван, хөдөөгийн бирааги зангуу	1	150-200	Бүх үе шатанд 7-14 хоногийн зайтайгаар хэрэглэнэ
Хүрэн манжин		1.5		Таримлын 2-4 жинхэнэ навчтай үе шатанд хог ургамлын 1 2р дэгдэлтийн үед 7-14 хоногийн зайтайгаар хэрэглэнэ. Таримал жинхэнэ навчтай үеэс 3.0л/га-аар хэрэглэж болно
Тэжээлийн манжин		3		Таримлын 4 жинхэнэ навчтай үе шатанд хог ургамал нялх байхад 1 удаа хэрэглэнэ.
Гурвалжин будаа		0.75		Таримлын жинхэнэ 1-2 навчтай үе шатанд хэрэглэнэ.

Худалдааны нэршил : БИЦЕПС ГАРАНТ КЭ

Хүлээх хугацаа: 60 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10°C) +40°C)-т 3 жил

Хог ургамлын гербицид

Үйлчлэх бодис: Хизалофоп-П-Этил 125г/л
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Нэг ба олон наст үет хог ургамалын эсрэг
Тариалангийн талбайн нэг ба олон наст үет хог ургамлын эсрэг тэмцэхэд зориулагдсан сонгомол үйлчилгээтэй соёололтын дараах гербицид.

• Хог ургамлын навч, ишээр бусад эд эрхтнүүдэд маш хурдан шингэж, үндэслэг иш болон нахианы өсөлтийн цэгт очиж үйлчилдэг системийн идэвхтэй үйлчилгээтэй

• Гербицид хэрэглэснээс хойш 7-10 хоногийн дараа хог ургамлын өсөлт зогсонги байдалд орсноор гэмтлийн шинж тэмдэг ажиглагддаг. Цаг агаарын байдлаас хамаарч 2-3 долоо хоногийн дараа ургамлыг үхэлд хүргэнэ.

• Бараг бүх зүйлийн үет хог ургамлыг устгадаг.

• Таримал ургамлын хөгжлийн ямарч үе шатанд хэрэглэх боломжтой.

• Хос үрийн талт хог ургамлын бусад гербицидтэй хольж хэрэглэхэд зохицол сайтай.



Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+8ºC) - (+25ºC)
Салхины хурд: 3 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 6 цагийн зайтай байх
Өвчин хортонд нэрвэгдсэн, гундсан таримал ургамал дээр хэрэглэхийг зөвлөдөггүй.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Төмс Лууван Сонгино Байцаа Вандуй	Мөлхөө хиаг, нэг наст биелэг, хонгио хошуу будаа, хоног будааны зүйл, тарианы хар будаа, бэрмэг, тагийн шиш, сибирь хялгана, биелэг өвс, ердийн зэгс, үнэгэн сүүл, газрын согоо, усан хоног элээ, хар дагуур сульхиаг, сибирь сульхиаг ,бага хургалж, хонин ботууль	0.4-1.2	100-200	Хог ургамлыг 2-4 навчтай болсон үеэс хэрэглэнэ
				Мөлхөө хиагийг 10-15 см өндөр болсон үед цацна
Маалинга				Тарималыг 2-4 навчтай болсон үеэс хэрэглэнэ
Рапс				Нэг наст хог ургамлыг 2-4 навчтай болсон үед
				Мөлхөө хиагийг 10-15 см өндөр болсон үед цацна

Худалдааны нэршил : Миура КЭ

Хүлээх хугацаа: 60 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-15°C) +35°C)-т 3 жил

Хог ургамлын гербицид

Үйлчлэх бодис: Клетодим 240г/л
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Нэг ба олон наст үет хог ургамалын эсрэг
Төмс, шар лууван, рапс, шар буурцаг, сонгины талбайн нэг наст үет (хоног будаа, тарианы хар будаа, зэрлэг бог будаа) болон олон наст үет хог ургамлын (хиаг, цагаан хялгана, жугар) эсрэг системийн үйлчилгээ үзүүлж ургамлын дээрхи болон үндэсний системд хүрч хог ургамлыг бүрэн устгадаг

• Хог ургамлын навч, ишээр бусад эд эрхтэнүүдэд маш хурдан шингэж, үндэслэг иш болон нахианы өсөлтийн цэгт очиж үйлчилдэг системийн идэвхтэй үйлчилгээтэй.

• Гербицид хэрэглэснээс хойш 7-10 хоногийн дараа хог ургамлын өсөлт зогсонги байдалд орсноор гэмтлийн шинж тэмдэг ажиглагддаг. Цаг агаарын байдлаас хамаарч 2-3 долоо хоногийн дараа ургамлыг үхэлд хүргэнэ.

• Хос үрийн талт хог ургамлын бусад гербицидтэй хольж хэрэглэхэд зохицол сайтай.



Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+0ºC) - (+20º C)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 6 цагийн зайтай байх

Таримал	Хог ургамал	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Төмс Шар Лууван, Сонгино, Рапс, Шар буурцаг	Нэг наст биелэг, хонгио хошуу будаа, хоног будааны зүйл, тарианы хар будаа, үнэгэн сүүл, мөлхөө хиаг	0.4-1.2	100-200	Таримлын ургалтын үе шатаас үл хамааран 1 наст үет хог ургамлын 2-6 навчтай үед, олон наст хог ургамлын (мөлхөө хиаг) 10-15 см өндөр үед зааврын дагуу хэрэглэнэ



Худалдааны нэршил : Клетомекс



Хүлээх хугацаа: 60 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-15°C) +35°C)-т 3 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Тиаметоксам 250г/кг
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Шавжийн эсрэг (Утсан өтний эсрэг)

Шавжийн төв мэдрэлийн систем дэх никотиний ацетилхолин рецептортой холбогдож, мэдрэлийн системийг хэт өдөөж, улмаар саажилт, үхэлд хүргэдэг. Неоникотинойд бүлгийн шавж устгах бодисууд нь хүн болон бусад зорилтот бус организмд хор багатай байдаг. Ургамлын сорох мэрэх амны эрхтэнтэй өргөн хүрээний шавж болох бөөс, навчит цохнууд, болон бусад төрлийн цох түүний авгалдай, эрвээхэй, түүний авгалдайны бүх үе шат, цагаан далавчтан зэргээс гадна хачиг, шоргоолж зэрэг олон төрлийн хөдөө аж ахуйн хортон шавжийг онилдог.



Хэрэглэх заавар:

Таримал	Төлөөлөх гол хортон шавж	Хэрэглэх тун норм кг/га	Ажлын уусмал	Хэрэглэх арга
Төмс	Утсан өт, Колорад цох, Няслуур цох, хөрсөнд амьдрах чадвартай хортон	0.06	200-400	Ургалтын үед урьдчилан сэргийлэх болон шавж үзэгдэж эхэлсэн үеэс хэрэглэх
Сонгино, сармис	Сонгины ялаа, сонгины өт	0.3-0.6		
Байцай	Ялаа бүүргэнэ (үсрэгч цох)	0.3	10000	Үрслэг шилжүүлэн суулгахаас 1-2 хоногийн өмнө талбайд цацна. Бодис цацахаас өмнө усалгаа хийхгүй байх
Хэмх (ил талбай)	Тамхины цацаг далавчтан, бөөс, цагаан далавчтан	0.8	200-400	Ургалтын үед навчаар
		0.12	2500-5000	Усалгааны системээр
Хэмх (хамгаалагдсан хөрс)	Тамхины цацаг далавчтан, бөөс, цагаан далавчтан	0.8		Дуслын усалгааны системээр таримал 1 метрээс бага үед
		0.4		Дуслын усалгааны системээр таримал 1 метрээс бага үед
Лооль	Колорад цох	0.8	200-400	Ургалтын үед навчаар
	Бөөс, цагаан далавчтан	0.12	2500-5000	Усалгааны системээр
Лооль, хаш	Бөөс, цагаан далавчтан	0.8		Дуслын усалгааны системээр таримал 1 метрээс бага үед
		0.4		Дуслын усалгааны системээр таримал 1 метрээс бага үед

Худалдааны нэршил : Актара ВДГ

Хүлээх хугацаа: 30 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10ºC) – (+35ºC) 4 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Имидаклоприд 150г/л + Лямбда цигалотрин 50г/л
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Хог ургамлын соёололтын эсрэг хөрсний гадаргууд бүрхүүл үүсгэх
Үйлчлэх механизм нь хортон шавжид хүрэлцэх болон хоол боловсруулах эрхтний замаар өөр төрлийн идэвхитэй бодисыг хослуулан агуулсан инсектицид.

- Олон төрлийн таримал дээр өргөн хүрээний хортонд үйлчилдэг.
- Ургамалд хуримтлагддаггүй, байгаль орчинд үзүүлэх хор нөлөө бага
- Богино хугацаанд 'нок даун' үйлчилдэг.
- Дайжуулах үйлчилгээтэй.



Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+10ºC) - (+30ºC)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3 цагийн зайтай байх

Таримал	Хөнөөлт организм	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Төмс, ил хөрсний улаан лооль	Колорадын цох хорхой	0.08-0.12	200-400	Дайжуулах зорилгоор болон ургалтын бүх үе шатанд хэрэглэнэ.
Сонгино	Сонгины ялаа	0.2-0.5		
Лууван	Луувангийн ялаа	0.12-0.2		
Байцааны үрслэг	Байцааны эрвээхэй, байцааны цагаан эрвээхэй, манжингийн цагаан эрвээхэй, байцааны бөөс, загалмай цэцгийн бөөс	0.1-0.14	300-400	
Байцаа үрээр	Бүүргэнэ, шөвгөр хошуут цох, ургамлын бөөс, манжингийн цагаан эрвээхэй	0.1-0.12	100-200	
Байцаа үрээр	Царцаа	0.1-0.15	300-400	

Худалдааны нэршил : БОРЕЙ СК

Хүлээх хугацаа: 28 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-5°C) +35°C)-т 3 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Лямбда-цигалотрин 50г/л
Аюулын зэрэг: 2 Дунд

Зориулалт:
Бэлчээр ойн хортон болон үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хортон, агуулахын хөнөөлт шавж, хачигтай тэмцэхэд хэрэглэнэ. Хортон шавжид хүрэлцэх болон хоол боловсруулах эрхтний замаар үйлчилнэ.

- Олон төрлийн таримал дээр өргөн хүрээний хортонд үйлчилдэг
- Ургамалд хуримтлагддаггүй, байгаль орчинд үзүүлэх хор нөлөө бага
- Богино хугацаанд “нок-даун” үйлчилдэг
- Дайжуулах үйлчилгээтэй



Хэрэглэх заавар:
Таримал ургамал, бэлчээрт хөнөөлт шавж олшрох үед шүршинэ.Бодисын үйлчилгээний хугацаа шавжийн төрөл болон цаг уурын нөхцөлөөс хамаарч 2-3 долоо хоног байна.

Таримал	Шавж	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Байцаа	Байцааны хивэн, Эрвээхийний хүрэнцэр, тооноложин	0.05	200-400	Талбайд ургалтын хугацаанд 1 удаа хэрэглэнэ
Төмс	Буглаа цох, бясаа, царцаа	0.2		
Сонгино	Сонгины ялааны авгалдай	0.15-0.2	200-300	25 хоногийн зайтай ургалтын хугацаанд 2 удаа хэрэглэж болно
Бэлчээр	Царцаа, нугын бор эрвээхий	0.1-0.2	200-400	Хөнөөлт шавж олшрох үед хэрэглэнэ
Үхрийн нүд	Бөөс, Хачиг, навчит шавж	0.15-0.2	800-1200	Ургалтын хугацаанд шавж идэвхтэй тархалтын үед 2 удаа

Худалдааны нэршил : Каратэ МКС

Хүлээх хугацаа: 20-30 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10°C) +35°C)-т 3 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Альфа-циперметрин 100г/л
Аюулын зэрэг: 2 Дунд

Зориулалт: Тариалангийн талбайн
Төмс, хүнсний ногоо ба бусад хөдөө аж ахуйн тарималд хөнөөл учруулдаг хортон шавжтай (бөөс, цацаг далавчтан, цикад, царцаа, шөвгөр хошуут цох, үетний ялаа, нөмрөгт бясаа, рапсын цэцэгч цох, тоонолжин цэцэгтийн бүүрэг, манжингийн бөөс, манжингийн навч хөндийлөгч, ялаа, вандуйн үрч цох, вандуйн бөөс, бясаанууд, царцаа) тэмцэх, урьдчилан сэргийлж дайжуулах үйлчилгээтэй инсектицид. Энэ нь шавжийн төв мэдрэлийн системийг гэмтээж эсийн мембраны нэвтрүүлэх чадварыг алдагдуулж, натрийн сувгийг хаадаг. Шавжийг хурдан үхэлд хүргэнэ.



Хэрэглэх заавар:
Таримал ургамал, бэлчээрт хөнөөлт шавж олшрох үед шүршинэ.
Бодисын үйлчилгээний хугацаа шавжийн төрөл болон цаг уурын нөхцөлөөс хамаарч 2-3 долоо хоног байна.

Таримал	Хөнөөлт организм	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га
Байцаа Манжин	Манжингийн цагаан эрвээхэй, Бүүргэнэ, Бүгэг эрвээхэй, Ургамлын бөөс, Навчны ширх ялаа	0.1-0.15	100-300
Төмс, лууван	Клорад цох, Буглаа цохнууд		
Эрдэнэшиш	Цикад, нугын бор эрвээхэй	0.1-0.2	200-400

Худалдааны нэршил : ФАСКОРД КЭ

Хүлээх хугацаа: 20 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-15°C) +30°C)-т 3 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Эсфевалерат 50г/л
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Байцаа манжингийн талбайн шавжийн эсрэг
Мэрэх болон сорох амны эрхтэнтэй хортон шавжуудад хүрэлцэх болон хоол боловсруулах замаар богино хугацаанд дайжуулах, хордуулах, үхүүлэх үйлчилгээтэй.
• Хортон шавжийг богино хугацаанд үхүүлдэг
• Давхар дайжуулах үйлчилгээтэй
• Нас бие гүйцсэн шавж, өт, авгалдайд адил үйлчилнэ



Хэрэглэх заавар:
Навчны гадаргууд тогтдог, ургамалд шингэхгүй тул бэлдмэлийг хур тунадас унаагүй үед, хурц наргүй өдөр өглөө оройн тогтуун цагаар ургамалд шүршилт хийх аргаар, хортны тоо толгой хэт олширсон тохиолдолд хэрэглэнэ.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Байцаа, Манжин	Байцааны болон манжингийн цагаан эрвээхий, бүгэг эрвээхий, хивэн эрвээхий	0.2	200-400	Таримлын ургалтын хугацаанд 30 хоногт 1 удаа





Худалдааны нэршил : СЭМПАЙ КЭ

Хүлээх хугацаа: 30 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10°C) +35°C)-т 3 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Имидаклоприд 220г/л
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Тариалангийн талбай, хүлэмж бэлчээрийн шавжийн эсрэг
Таримлын талбайн төрөл бүрийн хортон шавжтай тэмцэхэд зориулсан системийн үйлчилгээтэй инсектицид. Ургамлын бөөс, трипс, цагаан далавчтан зэрэг шавжаас гадна навч идэгч бүх төрлийн шавжид өргөн хүрээтэй үйлчилдэг. Навчинд шүршилт хийх, ургамлын орчим хөрсөнд хийх зэргээр хэрэглэнэ. Шавжийн төв мэдрэлийн системд үйлчилдэг, хөхтөн амьтдад бага хоруу чанартай байдаг.

Хэрэглэх заавар:
Агаарын хэм: +12ºC - +25ºC
Салхины хурд: 4м/с- ээс илүүгүй байх
Хур тунадас: 4 цагийн зайтай байх



Таримал	Хөнөөлт организм	Хэрэглэх бодисын тун л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Төмс	Колорад цох, бясаа бөөс, буглаа цохнууд	0.25	200-300	Ургалтын үед хэрэглэнэ
Хэмх Лооль Чинжүү Хаш	Тоорын бөөс гуатны бөөс, трипс, цагаан далавчтан, төмсний бөөс, манжингийн бөөс	0.3	300	
Чимэглэлийн ургамал	Бөөс, трипс, цагаан далавчтан, цох	0.04-0.08	100	
Чацаргана Үхрийн нүд	Ургамлын бөөс, бясаа, ялаа	0.25		Шавж үзэгдэж эхэлсэн цэгаас мод руу шүрших

Хүлээх хугацаа: 25 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10°C) +30°C)-т 3 жил

Шавжийн эсрэг инсектицид

Үйлчлэх бодис: Имидаклоприд 700г/кг
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Тариалангийн талбай, хүлэмж бэлчээрийн шавжийн эсрэг

Таримлын талбайн төрөл бүрийн хортон шавжтай тэмцэхэд зориулсан системийн үйлчилгээтэй инсектицид. Ургамлын бөөс, трипс, цагаан далавчтан зэрэг шавжаас гадна навч идэгч бүх төрлийн шавжид өргөн хүрээтэй үйлчилдэг. Навчинд шүршилт хийх, ургамлын орчим хөрсөнд хийх зэргээр хэрэглэнэ. Шавжийн төв мэдрэлийн системд үйлчилдэг, хөхтөн амьтдад бага хоруу чанартай байдаг.



Хэрэглэх заавар:
Агаарын хэм: +12ºC - +25ºC
Салхины хурд: 4м/с- ээс илүүгүй байх
Хур тунадас: 3-4 цагийн зайтай байх

Таримал	Хөнөөлт шавж	Хэрэглэх бодисын тун кг/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх арга, хугацаа
Төмс	Колорад цох, бясаа бөөс, буглаа цохнууд	0.05-0.125	200-400	Ургалтын үед хэрэглэнэ
Төмс(өрхийн хэрэглээнд)		0.3г буюу (3г-н 10/1)	5л ус-100мкв газар шүрших	
Хамгаалагдсан хөрс (хэмх лооль)	Ургамлын бөөс, цагаан далавчтан трипс	0.15-0.45	200-400	Усалгааны системээр 1000-3000л ус
Бэлчээр	Царцаа	0.15-0.3		Агаарын шүршигчээр 25-50л/га-аар ажлын уусмалын зарцуулалт тооцно
Модлог ургамал	Ургамлын бөөс, бясаа, ялаа	0.06		Урьдчилан сэргийлэх болон шавж үзэгдсэн үеэс хэрэглэнэ

Хүлээх хугацаа: 25 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10°C) +30°C)-т 3 жил

Хивэн эрвээхийн эсрэг био бэлдмэл

Үйлчлэх бодис: Bacillus thuringiensis var.курстаки 16000 IU/мг
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Bacillus thuringiensis var. kurstaki (Btk) нь хөрсөнд байгалиасаа оршдог бактер бөгөөд навчаар хооллодог хортон шавьжуудыг (жишээлбэл: трипс, царцаа эрвээхэйн авгалдай, байцааны навч идэгч (cabbage looper), улаан лоолийн эвэрт хорхой болон бусад навч идэгч авгалдай, харсан далавчтан болон тэдгээрийн өндөг, хүрэнцэр) мод, бут сөөг, улаан лооль, байцаа зэрэг хүнсний ногоон дээр хянахад нэн тохиромжтой.
Хамгийн үр дүнтэй үе нь шавжийн эхний болон хоёрдугаар авгалдайн (хүрэнцэр) үед буюу тэдгээр нь жижиг байх үе шатанд хэрэглэгдсэн тохиолдолд илэрдэг. Энэхүү бэлдмэлийг шавьж заавал идэж байж үйлчилдэг бөгөөд гэдэсний хордлогын замаар устгал явагддаг.



Давуу тал:
- Хортон шавьжийг халдварлуулж устгах,
- Хооллолтыг нь зогсоох,
- Өндөглөлтийг саатуулах,
- Хортон шавжийг ургамал руу татагдах сонирхлыг бууруулж, өөр газар шилжин холдох нөхцөл бүрдүүлдэг

Хэрэглэх заавар :

Таримал	Хэрэглэх тун (л/га)	Хөнөөлт организм	Хэрэглэх арга, хугацаа
Улаанбуудай, рапс	1-1,5кг/га	Хайрсан далавчтан, байцааны өт, бүгэг эрвээхэй, хивэн эрвээхэй, цагаан эрвээхэй, хос далавчтан, трипс, навч ороогч	Авгалдай 3р шатанд хүрэхээс өмнө хэрэглэнэ.
Цэцэгт ногоо байцаа, төмс, манжин	375-750г/га		Өндөг бойжих болон залуу авгалдайн үед
Эрдэнэшиш улаан лооль, өргөст хэмх	750-1500г/га		Өндөг бойжих үеэс эхний 1-2р шатны авгалдайд

Худалдааны нэршил : Bacillus thuringiensis var.курстаки (Btk)

Хүлээх хугацаа: 20 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-30°C) (+30°C)-т 2 жил

Гадаргуугийн идэвхжүүлэгч

Үйлчлэх бодис: Трисилоксан этоксилат
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт: Пестицидийн болон ураншийн бодисын үйлчлэлийг нэмэгдүүлэх
Пестицид болон уриншийн бодис, навчны бордоотой хамт хэрэглэхэд навчин дээр буух ажлын уусмалын шингэлт, нэвчилтийг сайжруулснаар бодис болон бордооны ашиглалтыг нэмэгдүүлдэг. Силикон суурьтай гадаргуугийн идэвхт бодис нь олон давуу талтай:
• Уриншийн бодисын үйлчлэлийг сайжруулна
• Ажлын уусмал навчны гадаргууд бүрэн, жигд тархаж бодисын үр нөлөөг дээшлүүлдэг
• Хөөсрөлт үүсдэггүй
• Навчны кутикулын давхарга нэвтрэх чадварыг нэмэгдүүлдэг.

- Ургамлын амьдрах хувь нэмэгдсэн
- Ургамлын үндэсний масс нэмэгддэг
- Ургацын чанар сайжирдаг

Хэрэглэх заавар:
Агаарын хэм: +10ºC - +25ºC
Салхины хурд: 3м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 30 минут
• Ажлын уусмалыг 24 цагийн дотор ашиглана
• Трисилоксан этоксилатыг хэрэглэх үед хор цацагчийн бункер дах өмнөх бодисын үлдэгдэл дараагийн тарималд хүчтэй үйлчлэх боломжтой тул бункерийг сайтар цэвэрлэх шаардлагатай.

Зориулалт	Хэрэглэх тун л/га	Ажлын уусмал л	Хэрэглэх арга, хугацаа
Бүх төрлийн навчны бордоо, пестицид, уриншийн бодис	0.1	3000	Ажлын уусмалыг бэлтгэхдээ шүршигчийн савны 80%-д усаа дүүргэж гадаргуугийн идэвхжүүлэгчээ нэмж хийн сайтар хутгана. Бэлэн болсон ажлын уусмал дээрээ пестицид болон бордоогоо нэмнэ. **1 литр** гадаргуугийн идэвхжүүлэгчийн ажлын уусмал 3000л байх ба пестицидийн ажлын уусмал 200л/га байх үед 15га-н зарцуулалт байна. **1 литр** гадаргуугийн идэвхжүүлэгчийн ажлын уусмал 3000л байх ба пестицидийн ажлын уусмал 300л/га байх үед 10га-д тус тус зарцуулна

Хүлээх хугацаа: 25 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10ºC) – (+30ºC)-т 3 жил


Гадаргуугийн идэвхжүүлэгч

Үйлчлэх бодис: Этоксилат изодецилийн спирт 900г/л
Аюулын зэрэг: 3 Дунд

Зориулалт:
Идэвхжүүлэгч нь гербицидийн ажлын уусмалыг навчнаас гулгах процессыг удаашруулж, навчинд сайн тогтож түүний гадаргуун дээр тархах бөгөөд дусал болгоны талбай хэд дахин томорно. Энэ нь гербицидийн уусмалаар навчны гадаргууг бүрэх нийт талбайг нэмэгдүүлнэ. Навчны гадаргуу үсэрхэг эсвэл лавын өнгөрөөр бүрхэгддэг навчтай хог ургамлын төрлүүдийг / гагадай, морин шарилж, мэхээр, сүүт өвс/, шигүү навчтай хог ургамлын төрлүүдийн / азаргана, тайжийн жинс, ганд бадраа/ гербицидтэй хэрэглэснээр тэдгээрийн устгах үр дүн өндөр байна. Гербицидийн ажлын уусмалд бодисыг нэмэхэд гербицидийн уусмал нь бороонд тэсвэртэй болдог.

Хэрэглэх заавар:
Гербицидийн ажлын уусмалыг бэлтгэхэд адьюг цэнэг сав руу хамгийн сүүлд хийх шаардлагатай, учир нь гербицидийг нэмэхэд хөөс бий болж савнаас асгарах магадлалтай байдаг.

Бэлдмэлийн тун (л/га)	Ажлын уусмал га
0.2	200





Худалдааны нэршил : Адью

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (-10ºC) – (+30ºC)-т 3 жил

Болц түргэсгэгч, хатаагч- Уринш

Үйлчлэх бодис: Дикват 200г/л
Аюулын зэрэг: 2 Дунд



Таримлын болцыг богино хугацаанд түргэсгэх хүрэлцэх үйлчлэл бүхий хатаагч бодис.
• Таримлын иш, навчийг аажмаар хатааж, навчаас булцуу руу шим тэжээл зөөвөрлөгдөн, булцуут ургамлын хальс бэхжин хураалтад бэлдэж өгдөг
• Десикаци хийх нь фитосанитар шинж чанартай тул ургац хураалтын үед болон хураалтын дараа хөрсөнд хадгалагддаг, мөн хог ургамлын үлдэгдэлд өвөлждөг өвчин үүсгэгчийн тоог бууруулж, тархалтыг хязгаарладаг чухал ач холбогдолтой.
• Хог ургамлын иш навчийг хатааж хураалтыг хөнгөвчилнө.
• 20-30 минутын дотор үйлчлэл нь явагдаж үр нөлөө нь 1 өдрийн дараа ажиглагдана.
• Идэвхтэй бодис нь ургамалд үйлчлэн хурдан задардаг тул хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй олон улсад хүлээн зөвшөөрсөн.

Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+10ºC) + (25ºC)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 2 цагын зайтай байх

Таримал	Хэрэглэх норм (л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Төмс	2.5-3.5	200-450	Хураалтаас 7-10 хоногийн өмнө
Сонгино			
Вандуй, шош, шар буурцаг	2.0-3.0	250-400	Үрийн чийг 45%-иас ихгүй үед
Уринш	3.5-4.0	200-400	Хог ургамлын идэвхтэй ургалтын үед

Худалдааны нэршил : Реглон

Хүлээх хугацаа: 7 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (0ºC) – (+30ºC)-т 2 жил

Өсөлт зохицуулагч / амин хүчлийн бордоо

Amino acid+ Epi brassinolide + Active Peptide Enzyme+Zn,Na

Ургамалд үзүүлэх нөлөө, ач холбогдол:

• Абиотик нөлөө буюу ган, хэт халалт, хуурайшилт, цочир хүйтрэлт, хяруу, мөндөр гэх мэт орчны таагүй нөхцөлөөс таримал ургамалд үзүүлж буй стрессээс урьдчилан сэргийлэх, стресс тайлах ач холбогдолтой. Ургамалд ус хадгалах, амьдрах чадварыг нь нэмэгдүүлж хамгаалах үүрэгтэй. Үндэс орчмын хөрсний чийгийг хадгалж барьдаг.

• Биотик нөлөө буюу Шавжны гэмтэл, өвчин үүсгэгчийг эсэргүүцэх, нөхөн төлжүүлэх ач холбогдолтой. Ургамлын өсөлтийг тэтгэж, шим тэжээлийг нэмэгдүүлэх олон төрлийн амин хүчил болон бичил элемент агуулсан учир ургамлын фотосинтезийн процессыг идэвхжүүлж, уургийн нийлэгжилтийг нэмэгдүүлж, үндсийг идэвхжүүлнэ.

• Навчны бордоотой хамт хэрэглэхэд, ургамлын стрессийн тэсвэр, шим бодисын шингээлт, зөөвөрлөлтийг дэмждэг бордоог ургамалд ашиглагдах хэлбэрт оруулдаг, эсийн түвшинд биологийн идэвхт үзүүлэх ач холбогдолтой.

• Ургамлын цэцэглэлтийг дэмжиж, үр жимсний хэмжээ болон чанарыг 20-25% нэмэгдүүлдэг.

• Нэгж га талбайгаас авах ургац нэмэгдүүлдэг.



Ургалтын үеийн бордоог хэрэглэх шалтгаан:

• Цаг агаарын таагүй үзэгдлүүд, тогтворгүй байдал нь (гангын давтамж,гэнэтийн аадар,мөндөр, цочир хүйтрэлт, хэт халалт) таримал ургамлыг стресст оруулдаг. Энэ нь таримлын ургалтын үе шатыг богиносгох, 1000 үрийн жинг багасгах, ургацыг бууруулах нэг шалтгаан болдог. Тиймээс таримлын гадаад орчны нөлөөнд өртөх эрсдэлийг бууруулах, ургацаа хамгаалах нэг шийдэлд био гаралтай өсөлт зохицуулагчийг хэрэглэх явдал юм.

Зориулалт	Хэрэглэх тун / га норм	1 га-д хэрэглэх усны хэмжээ	Хэрэглэх хугацаа	Хэрэглэх арга
Бүх төрлийн таримал ургамал	0.4-0.5 л/га	200л-400л/га	Ургалтын бүх үе шатанд	Доройтсон ургамлыг сэргээх, бордооны үйлчлэлийг нэмэгдүүлэх зорилгоор дангаар болон бордоотой хамт хэрэглэнэ.

Худалдааны нэршил : Амино BR

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (+5°C) +30°C)-т 3 жил

Бордоо

BR24

Зориулалт:

BR24 нь рапсын цэцгийн тосонд ихээр агуулагддаг ургамлын гормон юм. Ургамалд эсийн түвшинд үйлчилж өсөлт зохицуулж, идэвхжүүлснээр таримлын эрүүл эрчимт ургалтын эхлэл болдог. Үйлчлэх бодис Эпи-брассинолидийн онцгой шинж нь ургамлын дархлаа дэмжиж өвчин болон орчны тааламжгүй нөхцөлийг эсэргүүцэх чадварыг нэмэгдүүлдэг

- Ургамалд эпи-брассинолид нь эсийн түвшинд үйлчилснээр хэт халалт, ган, хүйтрэлт зэрэг орчны стрессийг тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлнэ
- Ургалтын үед навчаар үйлчилдэг бордоотой хамт хэрэглэхэд бордооны үйлчлэлийг давхар нэмэгдүүлдэг
- Пестицидийн стресс тайлдаг
- Үндэсний хөгжлийг дэмжин хүчирхэг үндэсний системийг бий болгодог.
- Тооноложин цэцэгтний овгийн тарималд маш сайн нөлөө үзүүлдэг.



Хэрэглэх заавар:

Агаарын хэм: (+10ºC) – (+25ºC)
Салхины хурд: 3м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3 цагийн зайтай байх

Таримал	Хэрэглэх тун л/га	Ажлын уусмал л/га
Улаанбуудай, арвай, овьёос, рапс, эрдэнэшиш, вандуй, байцаа, шар манжин, хүрэн манжин, төмс, лууван, сонгино, сармис	0.2-0.3	200

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (+5°C) +30°C)-т 3 жил

Худалдааны нэршил : BR24

Бордоо

N+P2O5+K2O>60% (15:3:5) + PAS ашигтай бичил организм+ микро элемент + байгалийн гаралтай өсөлт зохицуулагч

Зориулалт: Ургалтын үеийн навчаар үйлчлэх

Бүх төрлийн таримал ургамлыг (үр тариа, улаан буудай, рапс, эрдэнэшиш, төмс, хүнсний ногоо, жимс, жимгэнэ) бордоход тохиромжтой.

Cocoly бордоог бүх төрлийн усалгаагаар болон дараах аргаар хэрэглэж болдог. Үүнд:

- Навчинд шүрших
- Дуслын усалгааны системээр
- Гадаргуугийн усалгаагаар
- Тарилттай хамт
- Тарилтын өмнө хөрсөнд цацах гэх мэтээр хэрэглэхийг зөвлөдөг.
- Мөн ургамлын бордооны ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор бусад бордоотой хамт хольж хэрэглэж болно.



Хэрэглэх заавар:

- Таримлын ургалтын идэвхтэй үед 7-12 хоногийн давтамжтай хэрэглэнэ.
- Зөвлөсөн тун нормын дагуу бордоог хэрэглэнэ. Харин тухайн бүс нутгийн нөхцөлөөс хамааран хэрэглэх тун өөр өөр байж болно.

Хэрэглэх арга/зориулалт	Хэрэглэх тун кг/га	Ажлын уусмал л/га
Хөрсөнд (дангаар)	100кг-200кг	-
Бусад нийлмэл бордоотой хамт тарилтын өмнө болон үрлэгээний үед	0,2-0,4	-
Бүх төрлийн тарималд навчаар шим тэжээл өгөх зорилгоор`	0,2-0,4	200
Дуслын усалгаа болон бүх төрлийн гадаргуугийн усалгаагаар	0,2-0,4	1000
Үрслэг бойжуулахад	1 ширхэг мөхлөг	500мл - 800мл

Энэхүү бүтээгдэхүүн нь хүчиллэг болон шүлтлэг химийн бодис эсвэл бусад төрлийн бордоотой хамт хэрэглэхэд аюулгүй бөгөөд цацах үед хурц нартай, агаарын температур хэт өндөр эсвэл бороотой үед хэрэглэхээс зайлсхийж, хуурай нөхцөлд хадгална. Хүүхдээс хол байлгах шаардлагатай.

Худалдааны нэршил : Коколи

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (+5°C) +30°C)-т 3 жил

Бордоо

N+P2O5+K2O>60% (13:7:40)

Зориулалт: Ургалтын үеийн навчаар үйлчлэх

К хүч нь калийн өндөр агууламжтай тул усанд бүрэн уусдаг, таримлын ургалтын үед навчаар үйлчилдэг өндөр үр ашигтай, ургацыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг нийлмэл бордоо юм.

• Хүрээлэн буй орчинд ээлтэй
•Ургамал хамгаалах бодис болон бусад төрлийн бордоотой нийлэмжтэй
• Гербицидээс үүсэх стрессийг бууруулна
• Таримлын чийгийн нийт алдагдаг бууруулна
• Үрийн цутгалт болон жин, массыг нэмэгдүүлнэ
• Үр боловсрох хугацааг түргэсгэнэ
• Бүх төрлийн таримлын үрийн ургац дээшлүүлэхээс гадна ургацын чанарыг нэмэгдүүлнэ

Таримал ургамал калийн дутагдалд орсноор ургамлын газрын дээд эрхтэн, үндэсний өсөлт,хүйтэн болон налалтад тэсвэрлэх чадвар буурч үрийн ургац буурна.



Хэрэглэх заавар:

Таримлын ургалтын хугацаанд нийт 3 удаа хэрэглэж болно.

N хүч + K хүч + BR24 ; K хүч + BR24 ; K хүч

Таримал	Га/норм кг/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх хугацаа
Төмс, байцаа, лууван, сонгино, сармис, шар манжин, хүрэн манжин	0.2-0.3	200	Шим тэжээлийн дутагдалын шинж тэмдэг илэрсэн үед, ургалтын дунд үе шатанд (үр, жимс, булцууны хөгжил болон ургацын чанарыг нэмэгдүүлэх зорилгоор)

Худалдааны нэршил : К хүч бордоо

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (+5°C) +30°C)-т 3 жил

Бордоо

N+P2O5+K2O>60% (20:20:20) TE

Зориулалт: Ургалтын үеийн навчаар үйлчлэх

Бүх төрлийн тарималд ургалтын үед навчаар үйлчлэн цогц тэжээл өгч таримлын чанар болон ургацыг нэмэгдүүлдэг. Азот, фосфор, калийн өндөр агууламжтай, усанд бүрэн уусдаг нийлмэл бордоо нь ургалтын эхэн үеэс л таримлыг шим тэжээллээр хангах, ногоон. массыг нэмэгдүүлэх, үндэсний хөгжлийг дэмжих, ургалтын эрчим нэмэгдүүлэх үр нөлөөтэй.

• Таримлын хүйтэнд болон ганд, өвчин хортонд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлнэ.
• Гербицидээс үүсэх стрессийг бууруулна.
• Таримлын чийгийн нийт алдагдал бууруулна.
• Үрийн цутгалт болон жин, массыг нэмэгдүүлнэ.



Хэрэглэх заавар:

Таримлын ургалтын эхэн үеэс дунд үе хүртэл таримал бүрийн онцлогоос хамаарч 2-4 удаа навчаар бордоно.
NPK 20:20:20 > 60% + TE
N хүч

Таримал	N хүч кг/га	K хүч кг/га	BR24 л/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх хугацаа
Бүх төрлийн хүнсний ногоо	0.2-0.3	0.2-0.3	0.1-0.2	200	Бутлалт жигдрэх үеэс навчаар, Жинхэнэ 3-4 навчтай үеэс иш үүсэх хүртэл, Ургалтын бүх үе шатанд

Худалдааны нэршил : N хүч бордоо

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (+5°C) +30°C)-т 3 жил

Бордоо

Борын бордоо

Зориулалт: Ургалтын үеийн

Бүх төрлийн тарималд ургалтын үед навчаар шүршиж хэрэглэхэд шим тэжээлээр хангаж, таримлын чанар болон ургацыг нэмэгдүүлдэг, цэцэглэлтийг дэмждэг чухал элемэнт юм.

• Бор нь ургамлын нүүрс ус, уураг болон нуклейн солилцоонд оролцож, эсийн хуваагдал, аминхүчил үйлдвэрлэлд чухал үүрэг гүйцэтгэдэг.

• Бор нь фосфорын хэрэглээг нэмэгдүүлж өсөлтийн цэг рүү шилжих хөдөлгөөнийг хурдасгаж болц түргэсгэдэг.

• Таримлын хүйтэнд болон ганд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлдэг.

• Цэцэглэлтийг нэмэгдүүлэх нь үр жимсний гарцыг төдий чинээ нэмэгдүүлдэг.

Борын дутагдал нь ургамалд:

• Ургамлын оройн хэсгийн өсөлт буурч, үндэсний системийн хөгжил удааширдаг.

• Үржлийн үе шатыг гажуудуулж, үржлийн эрхтний хэлбэржилт, цэцэглэлт, жимслэлтийг зогсонги байдалд оруулна.

• Үр тарианы таримлын хувьд борын хурц дутагдлын үед хажуугийн нахиануудаас түрүү үүсдэггүй.

• Тосны таримал рапсын хувьд бор дутагдах үед иш бүдүүрч, цэцэглэлт удааширч хонхорцгийн хэмжээ багасаж үрийн гарц буурдаг.



Хэрэглэх заавар:

Ургалтын эхэн үед N хүч K хүч бордоотой хамт зөвлөсөн тунгаар хэрэглэх нь бүх төрлийн таримлын үндэсний системийн хөгжлийг дэмждэг.

1. Үр тарианд ургалтын эхэн үед бордоход бутлалтын явцыг идэвхжүүлнэ
2. 2 дахь бордолтын үед түрүү үүсэлтийг дэмжиж, үрийн цутгалтад сайнаар нөлөөлдөг.

Таримал	Bo21% кг/га	Ажлын уусмал л/га	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай бусад үр тариана ургамал	1.5-2.0	200	Бутлалтаас түрүүлэлтийн үе шатанд
Рапс	1.5-2.0		4-6 навчтай үеэс цэцэглэлтийн үе хүртэл
Ногоон тэжээл	1.5-2.0		Ургалтын эхэн үед

Худалдааны нэршил : Bo21%

Хүлээх хугацаа: 40 хоног
Хадгалах нөхцөл, хугацаа: (+5°C) +30°C)-т 3 жил



AminoBR

- Цочрол хүйтрэл
- Соёололтыг идэвхижүүлэх
- Ургамлын өсөлтийг дэмжигч
- Гэмтлийг нөхөн төлжүүлэгч
- Ган, хэт халалт хуурайшилтын эсрэг

ТАРИМАЛ УРГАМАЛ



Ургах Бухнийг URGA.MN-с

САЛБАР-1
БЗД, 3-Р ХОРОО, АРСЛАНТАЙ ГҮҮР,
ХХААЯамны ХОЙНО, 20/2-Р БАЙР
7272-0808

САЛБАР-2 / ТӨВ
БЗД, 1-Р ХОРОО, ЗАЛУУЧУУДЫН ӨРГӨН
ЧӨЛӨӨ-21, САНСАРЫН И-МАРТЫН
ЗАМЫН ХОЙНО НОРТ ЦЕНТР 109 ТООТ
7272-0808
6690-9090

САЛБАР-3 / УХБодисын агуулах
СХД, 32-Р ХОРОО 384 ГАРАМ,
29 ГУДАМЖ 62А ТООТ
9997-9628
6690-9090

Ургамал хамгааллын зөвлөх мэргэжилтнүүд:
6012-1212
6014-1414
8894-0052

Таримал Ургамал ХХК

tarimalurgamal2016@gmail.com
tarimalurgamal2016@urga.mn